



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/205

Улаанбаатар хот

┌ Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны ┐
“Гүн мэдрэмж” өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,648,438.50 (таван сая зургаан зуун дөчин найман мянга дөрвөн зуун гучин найман төгрөг тавин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны “Гүн мэдрэмж” өрхийн эрүүл мэндийн төв (Л.Одончимэг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 18 нэр төрлийн 3,883,438.50 (гурван сая найман зуун наян гурван мянга дөрвөн зуун гучин найман төгрөг тавин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 3 нэр төрлийн 1,765,000 (нэг сая долоон зуун жаран таван мянга) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсаны орлогын 30 хувь 6,600 (зургаан мянга зургаан зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны “Гүн мэдрэмж” өрхийн эрүүл мэндийн төв (Л.Одончимэг)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000595

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн А/22.5 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 15-р хорооны Гүн мэдрэмж ӨЭМТөв

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	Мэргэжлтийн санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж													
1	Гүйлтийн зам	11	ш	1	315,000.00	315,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	15,000	15,000
2	Жийдэг унадаг дугуй	11	ш	1	268,000.00	268,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
3	Зөөврийн компьютер	9	ш	1	1,000,000.0	1,000,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	5,000	5,000
4	Зургийн аппарат	9	ш	1	279,000.00	279,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
5	Индүү	7	ш	1	27,900.00	27,900.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
6	Компьютерийн процессор	6	ш	1	779,990.00	779,990.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
7	Нурууны иллэгийн аппарат	11	ш	1	70,000.00	70,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
8	Пульс тоологч	8	ш	1	147,600.00	147,600.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
9	Сахар хэмжигч аппарат	7	ш	1	88,000.00	88,000.00	12,833.06		Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
10	Таблет	6	ш	1	450,000.00	450,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	2,000	2,000
11	Товгортой цагираг	11	ш	1	25,000.00	25,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
12	Тоос сорогч	10	ш	1	79,000.00	79,000.00		-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах

